

PRODUCTION



**РАЖИВ ГАНДИЙН НЭРЭМЖИТ
ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ**



**РАЖИВ ГАНДИЙН НЭРЭМЖИТ ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ДҮРЭМ, ЖУРМЫН ЭМХТГЭЛ**

УЛААНБААТАР - 2019

РАЖИВ ГАНДИЙН НЭРЭМЖИТ ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИД СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1.1 Энэхүү журмын зорилго нь Үйлдвэрлэл2Урлалын Политехник коллеж /цаашид2“Сургалтын байгууллага” гэх/-д техникийн боловсрол, мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалтын элсэлтийг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 Үйл ажиллагаандаа хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн элсэлт зохион байгуулах2үндсэн зарчмыг2баримтлан2холбогдох2хууль тогтоомжид нийцүүлэн ажиллана.

1.3 Энэхүү журам болон элсэлт авах мэргэжил, шалгалтын чиглэл, элсэлтийн ажлын зохион байгуулалттай холбоотой мэдээллийг Үйлдвэрлэл Урлалын Политехник коллежийн /www.pas.mn/ цахим хуудсанд байршуулна.

ХОЁР. СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ, ХЯНАЛТЫН ТООНЫ САНАЛ ХҮРГҮҮЛЭХ

2.1 Сургалтын байгууллагад элсэлт зохион байгуулах мэргэжлийн чиглэл, хяналтын тооны саналаа Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл /цаашид “зөвлөл” гэх/-ийн орон нутгийн салбар зөвлөлтэй зөвшилцөж хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, байгууллагынхаа хүчин чадал, багш нарын ур чадвар, нөөцийн түвшин, дадлагын бааз, сургалтын орчны бүрдэлт, бүс орон нутгийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсруулж, жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар/-д хүргүүлнэ.

2.2 Сургалтын байгууллагын хяналтын тооны саналыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгтгэх ба Зөвлөл хэлэлцэн зөвлөмж гаргана.

2.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авсан оюутны хяналтын тоонд нийцүүлэн өөрийн байгууллагын нөөц хүчин чадалд тохируулан сургалт явуулах тусгай зөвшөөрөлд заагдсан мэргэжлүүдийн дагуу суралцагч элсүүлнэ.

24 Элсэгч хяналтын тоонд хүрээгүй тохиолдолд жил бүрийн элсүүлэх үйл ажиллагааг 9 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл зохион

байгуулах ба шаардлагатай гэж үзвэл төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн чиглэлийн дагуу хугацааг сунгаж нэмэлт элсэлтийг зохион байгуулж болно. Түүнчлэн мэргэжлийн индексийн жилээс хамааран 1.5 жилээр төгсөгчдийн элсэлтийг 2 дугаар сард зохион байгуулж болно.

25 Мэргэжлийн сургалтыг нийгмийн түншлэгчид болон ажил олгогчид, үйлдвэр аж ахуйн газартай харилцан тохиролцсоны үндсэн дээр сургуулийн хүчин чадал, сургалтын орчинд нийцүүлж сургалт эхлэх огноог уян хатан байдлаар зохицуулан зохион байгуулж болно.

26 Сургалтын захиалгыг урьдчилан төлөвлөж, элсэлтийн тооны саналдаа тусгасан байх ба тухайн оны 11 дүгээр сарын 01-ний дотор элсэгчдийн мэдээллийг болон статистик мэдээг Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлснээр ногдох санхүүжилтийг авах эрхтэй болно.

ГУРАВ. ЭЛСЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

31 Оюутан элсүүлэх ажлын гол зорилго нь шалгуулагчдын сурах чадвар, мэдлэгийн түвшин, авъяасыг бодитойгоор үнэлж, цаашид амжилттай суралцах чадвартай хүмүүсийг шалгаруулан элсүүлэхэд оршино.

32 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд өдрийн, оройн, хосмог сургалтын хэлбэрээр суралцагч элсүүлж болно.

33 Мэргэжлийн боловсрол олгох сургалтад суурь боловсролтой иргэнийг элсүүлнэ.

34 Техникийн боловсрол олгох сургалтад бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой иргэнийг элсүүлнэ.

35 Мэргэжлийн сургалтад мэргэжлийн ур чадварын түвшин, боловсролын түвшин харгалзахгүйгээр элсүүлнэ.

36 Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт нь төрийн захиргааны төв байгууллагаас баталсан сургалтын стандарт, хөтөлбөрт заасан хугацаагаар сургалт явуулна.

37 Элсэхийг хүсэгчдийн өргөдөл материалыг жил бүр зарлагдсан хугацааны дотор сургууль дээр элсэлтийн комисс хүлээн авна.

38 Сургуульд элсэх хүсэлтийг өөрийн биеэр болон дараах шуудангийн хаяг, утас, факсаар хүлээж авна.

- Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ногоон нуурын гудамж, 10-р хороо
Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж

- Харилцах утас: 350209,

- Факс (976-11) 350209

39 Элсэлттэй холбоотой гарсан санал, гомдлыг сургуулийн захирлын тушаалаар баталсан Элсэлтийн комисс өөрийн эрх, үүргийн

хүрээнд зохицуулна.

3.10 Элсэлтийн комисс нь ажлын тайланг элсэлт дууссанаас хойш 14 хоногийн дотор захиргааны зөвлөлд танилцуулна.

ДӨРӨВ. ЭЛСЭГЧДИЙН ШАЛГАРУУЛАЛТ

4.1 Элсэгчдэд тавигдах нийтлэг болон тусгай шаардлагыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн сургалтын байгууллагын элсэлтийн журамд тусгаж баталгаажуулан мөрдөж ажиллана.

4.2 Элсэхийг хүсэгчид нь суралцах эрхийн бичиг авахдаа дараах бичиг баримтыг авчирнэ. Үүнд:

Суурь болон бүрэн дунд боловсролын үнэмлэх

- Суралцагчийн хувийн хэрэг

- Иргэний үнэмлэхний баталгаажуулсан хуулбар

- 3*4 хэмжээтэй 4 хувь цээж зураг

4.3 Элсэгчид жил бүрийн 8 дугаар сарын 25-наас 31-ний хооронд сургуулийн хичээлийн байранд биеэр ирж бүртгүүлэх бөгөөд бүртгүүлэхдээ дараах бичиг баримтыг авч ирж бүрдүүлэх шаардлагатай. Үүнд:

- Эрүүл мэндийн дэвтэр /бөглөлт хийлгэж, баталгаажуулсан байна./

- Элсэлтийн хураамжны төлбөр төлсөн баримт

- Суурь болон бүрэн дунд боловсролын үнэмлэх

4.4 Элсэлтийн ажлыг оновчтой болгох үүднээс мэдлэг, ур чадварын түвшин тогтоох шалгалт авч болно.

4.5 Мэргэжлийн боловсрол олгох сургалтад элсэгчдийг сонгон шалгаруулахдаа суурь боловсролын гэрчилгээний дундаж оноо, түвшин тогтоох шалгалтыг харгалзан үзнэ.

4.6 Техникийн боловсрол олгох сургалтад элсэгчдээс элсэх мэргэжлийн ерөнхий суурь хэсгийн буюу технологийн хичээлээр шалгалт авна.

4.7 Урлагийн мэргэжлийн ангиудад элсэх хүсэлт гаргасан суралцагчдаас ур чадварын шалгалт авна.

4.8 Ерөнхий боловсролын сургуулийг “А” болон “В” үнэлгээтэй төгсөгчид, эсвэл улс, аймгийн олимпиадад аймаг, сумаас шалгарч оролцсон суралцагчийг тухайн мэргэжлээр элсэхийг хүсвэл суурь эсвэл бүрэн дунд боловсрол эзэмшсэн нөхцөлд дараалал харгалзахгүй элсүүлнэ.

4.9 Сонгон шалгаруулалтад тэнцсэн элсэгчдэд суралцах эрхийн бичгийг сургалтын байгууллагаас олгох бөгөөд тайланг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.